



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/458

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн "Хөтөлбөр батлах тухай" 56 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам шинэчлэн балтах тухай" 61 дүгээр тушаалын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Улаан загалмайн хорооны байрны халаалтын системийн холболтын зардалд 5,000,000 (таван сая), Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын техник хэрэгслэл, телекамер авахад 3,389,000 (гурван сая гурван зуун наян есөн мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх 8,389,000 (найман сая гурван зуун наян есөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100971

D:My Doc. Zahiramj. Zasag darga